




ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК
ТӨВРӨГ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ- 2020 онд /урьдчилсан дүнгээр/



2021.01.25



ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2020 онд 1455 эх амаржиж, 1461 хүүхэд шинээр мэндэлж, 333 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оноос 104(7.7%)-өөр, төрсөн хүүхдийн тоо 103(7.6%)-аар тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оноос 66(16.5%)-аар буурсан байна.



Нялхсын эндэгдэл 13 байгаа нь өмнөх оноос 3-аар өсчээ.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй



Халдварт өвчний 914 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 205-аар буюу 18.3 хувиар буурчээ.




Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 50.0 хувиар, трихоминиаз 41.9 хувиар, тэмбүү 33.3 хувиар, заг хүйтэн 29.9 хувиар, сүрьеэ 15.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




ЭРҮҮЛ МЭНД


Урьдчилан сэргийлэх тарилга



Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо




Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох



Эмчлүүлсэн хүн	-2.9%	▼
Амбулторын үзлэг	-3.1%	▼
Урьдчилан сэргийлэх тарилга	+1.5%	▲
Нялхсын эндэгдэл	+30.0%	▲

ЭРҮҮЛ МЭНД

Нас баралт өвчний шалтгаанаар 2020 онд






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 12 сард 294 болсны 121 (41.2%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 173 (58.8%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 6(2.0%) хүнээр, өмнөх сараас 78(21.0%) хүнээр тус тус буурсан байна.




1338 иргэн ажилд зуучлагдан оржээ


Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны 12 сард 103 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 214 иргэн ажилд зуучлагдан орж, 191 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.



Ажилгүй иргэдийн тоо, сумаар



Шинээр бий болгосон ажлын байр, э.з-ийн салбарын ангилалаар



Нийгмийн даатгалын сан



2020 онд даатгалын сангийн

- орлого 42965.7 сая төгрөг /өмнөх оноос 1.9 % / ↑
- зарлага 61985.0 сая төгрөг /өмнөх оноос 20.3 % / болж ↑.

Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 45308.5 (73.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 8558.8 (13.8%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 3631.6 (5.9%) сая.төг, YOMШӨ-ний даатгалын сангаас 2967.7 (4.8%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1518.4 (2.4%) сая төгрөгийг зарцуулжээ.

Нийгмийн халамжийн сан



Нийгмийн халамжийн сангаас 2020 онд


- 25878 мянган хүнд /өмнөх оноос 9.6% / ↓
- 8925.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж /өмнөх оноос 1.7% ↑/ олгожээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоо буурахад ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт авсан хүн 3849 (46.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлөв.



БОЛОВСРОЛ

Бүх шатны сургуульд суралцагчид



Ерөнхий боловсролын сургуульд

2020/2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуульд 14629 сурагч суралцаж байгаа нь өмнөх оноос 658(4.7%)-аар өссөн байна.

Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1132 оюутан суралцаж байгаа өмнөх оноос 377(49.89)-оор өсчээ.



Их, дээд сургууль, коллежид

АШУҮИС-д 597 оюутан суралцаж байгаа өмнөх оноос 122(25.7)-оор өсчээ.



ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 онд 318 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 132 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнө оноос 232(42.2%)-оор , гэмтсэн хүний тоо 90 (40.5%) -ээр, нас барсан хүний тоо 14 (58.3%)-өөр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнө онтой харьцуулбал хүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 75(34.9%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 73(43.2%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15(55.6%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 21(65.6%)-ээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 18(40.9%)-аар, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 5(50.0%)-аар, авлигын гэмт хэрэг 6(85.7%)-аар, хүний халдашгүй, чөлөөт байх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(60.0%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2(11.1%)-оор тус тус буурчээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1127.6 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнө онтой харьцуулахад 2431.3 (68.3 %) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлын 814.8 (72.3%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.



ГЭМТ ХЭРЭГ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2019 550
2020 318



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

215
140



Залилах

31
37



Хулгайлах

107
61



Мал хулгайлах

26
19



Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг

10
5



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

44
26



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

169
96




Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн тоо өмнө оноос Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-үүд сумдад буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.





БАНК, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг




- Нийт хадгаламж 43.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
- Нэг хадгаламж эзэмшигчдэд 2062.2 мянган төгрөг ногдож байна
- Нэг хүнд дундажаар 2334.8 мянган төгрөг ногдож байна.
- Хадгаламж эзэмшигчийн тоо 8.5 % нэмэгдсэн
- Иргэдийн хугацаатай хадгаламжийн үлдэгдэл 27.1 % өссөн
- Зээлдэгчийн тоо 3.3 хувиар буурсан
- Нийт зээлийн үлдэгдэл 11.4 хувиар буурсан



МӨНГӨ,ЗЭЭЛ



ЗЭЭЛ,төрлөөр, дүнд эзлэх хувиар 2020 онд



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр 2020 онд





ТӨСӨВ, САНХҮҮ

2020 онд орон нутгийн төсөвт 37360.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 82443.1 сая төгрөг зарцуулжээ.



Орон нутгийн төсвийн орлого, сая төг

79334.0 37360.7

2019

2020

Орон нутгийн төсвийн зарлага, сая төг

69022.3 82443.1

2019

2020

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.4 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 4.3 хувь, тээврийн бүлэг 1.4 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 0.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.




Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 6.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.6 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 5.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 4.0 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 6.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.





Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2016 - 2020 оны сар бүрээр (өмнөх оны 12-р сар=100)





Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн сарын өөрчлөлт, сүүлийн 5 жилээр, хувиар (өмнөх оны 12-р сар=100)



Хамгийн бага
өсөлт




Хамгийн их
өсөлт

Инфляци нь үнийн ерөнхий түвшний өөрчлөлтийг харуулах бөгөөд хэрэглээний, бараа үйлчилгээний индекс(ХҮИ)-ээр "хувь"-иар илэрхийлэгдэнэ



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2019-2020 оны сар бүрээр (өмнөх сар= 100)



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 2020 оны урьдчилсан байдлаар 2551.5 мянган толгой мал тоологдсон. Нийт мал сүрэг 2019 оноос 6.1 хувь буюу 147.3 мянган толгойгоор өсчээ.



АДУУ:

165.0 мянган толгой, өмнөх оноос 8.1 хувиар өслөө.



ТЭМЭЭ:

45.4 мянган толгой, өмнөх оноос 4.3 хувиар өслөө.



ҮХЭР:

103.7 мянган толгой, өмнөх оноос 12.9 хувиар өслөө.



ХОНЬ:

1069.7 мянган толгой, өмнөх оноос 4.7 хувиар өслөө.



ЯМАА:

1167.7 мянган толгой, өмнөх оноос 6.7 хувиар өслөө.


2020 онд оны эхний нийт хээлтэгч малын 804.0 (79.6%) мянган эх мал төллөж, гарсан төлийн 803.1 (98.9%) мянган төл бойжуулжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад бойжсон төл 5.6 хувиар өссөн байна.

2020 онд 10.9 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.5 хувьтай тэнцэж байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИК АГЫН
ТӨВ
УЛААНБААТАР



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Малын тоо, толгойн дээд хэмжээ хүрсэн онууд, мянган.толгой




	Аймаг байгуулагдсанаас хойш	
	<i>мян.тол</i>	<i>он</i>
Бүгд	2551.5	2020
Тэмээ	121.2	1954
Адуу	165.0	2020
Үхэр	145.1	1940
Хонь	1069.7	2020
Ямаа	1167.7	2020



ХӨДӨӨ АЖ АХУЙ


Малын тоо, сумаар, мянган толгойгоор



ᠬᠥᠳᠡᠭᠡ ᠠᠵᠤ ᠠᠬᠤ



ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ СУМДУУД, малын төрлөөр, толгойгоор



АДУУ

Дэлгэрэх	16979
Хатанбулаг	15802
Эрдэнэ	15199
Улаанбадрах	13835
Сайхандулаан	12647



ХОНЬ

Дэлгэрэх	122151
Даланжаргалан	107985
Айраг	102725
Иххэт	97435
Хатанбулаг	85967

НИЙТ МАЛ

Хатанбулаг	284155
Дэлгэрэх	234290
Даланжаргалан	210571
Айраг	202214
Сайхандулаан	199263



ТЭМЭЭ

Мандах	8528
Хатанбулаг	8418
Улаанбадрах	5573
Хөвсгөл	5518
Сайхандулаан	4763



ҮХЭР

Хатанбулаг	11905
Дэлгэрэх	10757
Иххэт	9333
Өргөн	9245
Эрдэнэ	8825



ЯМАА

Хатанбулаг	162063
Мандах	107185
Хөвсгөл	99252
Сайхандулаан	89015
Даланжаргалан	84179

АЖ ҮЙЛДВЭР



2020 оны 12-р сард аж үйлдвэрийн салбарт оны үнээр 182.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 13.3 (6.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны 12-р сард 293. тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9(1.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбарт эзлэх хувиар

2019 он



2020 он



2020 онд өмнөх оноос \пунктээр\

УҮГ 1.1 ↑

Компани 1.2 ↓

Өрхийн аж ахуй 0.1 ↑





ЦАГ УУР

2020 оны 12 дугаар сард

Агаарын дундаж температур (°C)

Хамгийн бага температур
Эрдэнэ сум



Хамгийн их температур
Хатанбулаг сум





WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН



Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

www.dornogovi.nso.mn